

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**МОНГОЛЫН ФЕОДАЛЫН НЭГДСЭН УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭВ ЗАНШЛУУД****Ж. Бор**

XIII зууны эхэн үед монголын феодалын нэгдсэн төр улс бүрэлдэн тогтож, улмаар харь олон орныг байлдан дагуулж, монгол гүрэн байгуулагджээ. Энэ үед монгол гүрний гадаад харилцаа өргөжсөн нь урьдхаасаа илүү нарийн дипломат арга ажиллагааг шаардах болсон байна. Энэ үеийн монголын гадаад харилцааг ул үндэстэй хөндөн судлах нь чухал юм. Монгол гүрний гадаад харилцааны талаар хөрөнгөтний зарим бурангуй харгис үзэлтнүүд хийгээд маогийнхан бодит түүхийг гуйвуулж, монголчуудыг дипломат ёс горим, олон улсын хэв заншлыг мэдэхгүй байсан мэтээр үнэлэх, эсвэл хэт дөвийлгөн жанжлах санаархалдаа ашиглах гэсэн хандлага ажиглагдсаар байгаа юм.

XII зууны сүүл, XIII зууны эхэн үеэр Монгол орон нь олон жижиг аймаг, томоохон аймгуудын холбоо, феодалын түрүү үеийн улс ханлигуудын байдлаар саланги тархай оршиж байв. Тэдгээрийн дундаас Хамаг монгол, Хэрэйд, Найман, Мэргэд, Татаар зэрэг хүчирхэг ханлигууд нь ихээхэн биеэ даасан бодлого явуулж, өвөр хоорондоо хийгээд түүнчлэн хойт ба өмнөд Хятадад тогтож агсан Алтан улс, Сүн улстай улс төр, эдийн засаг, соёлын харилцааг барьж байжээ.

Феодалын нийгмийн үед феодалууд нь өөрийн эзэмшилд биеэ даасан бүрэн эрхтэй байдгийн нэгэн адилаар феодалын түрүү үеийн улс гүрнүүд ч гэсэн тусгаар тогтносон төр улсын ёсоор оршин тогтнож байв. Энэ нь олон улсын эрхийн гол зарчмуудын нэгэн болох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тухай зарчмыг туйлын утгаар нь хэрэгжүүлэх хийгээд элчин харилцааны эрх зүйн хэмжээг боловсронгуй болгоход зохих үр нөлөө үзүүлжээ.

Тиймээс ч аймгийн холбоо, ханлигуудын толгойлогчдын эрх мэдэл ихээхэн өсч өөрийн улсын тусгаар тогтнол нутаг дэвсгэрийн халдашгүй байдал болон улс төрийн бүрэн эрхээ хамгаалахын зэрэгцээ дайн ба найрамдлын асуудлыг шийдвэрлэж байв. Жишээ нь: Хамаг монгол улс Зүрчидийн Алтан улсын довтолгооныг амжилттай няцааж, 1147 онд найрамдлын гэрээ байгуулж байв.¹ Хамаг монголчууд энэ дагуу бөгөөд өөртөө ашигтай гэрээг байгуулсан нь Алтан улс лугаа эн зэрэгцэх улс болж болохыг харуулж тэдний нэр хүндийг Төв Ази дахинд батжуулсан хэрэг болжээ.

Феодализмын үед дайн нь олон улсын харилцааны түгээмэл хэлбэр байснаас «хэн хүчтэйгийнх нь зөв» гэсэн бурангуй хууль улсын дотоодод хийгээд гадаад харилцаанд ноёлж байлаа. Тиймээс дундад

¹И. Бичурин «Записки о Монголии», т. П, СП б. 1828, 151-р тал

зууны монголчууд нь ханлиг, тэр ч атугай аймаг, овог хооронд явагдаж агсан эцэс төгсгөлгүй дайны асуудлыг зохицуулах зорилгоор цэрэг дайны зарим нэгэн ёс журмын цогцосыг бий болгожээ. Энэхүү ёс журам нь хэдийгээр феодалын самуун дайны хахир ширүүн шинжийг зөөлрүүлж чадаагүй боловч бага хэмжээний тодорхой үүрэг гүйцэтгэсэн байна. Хэдийгээр ханлиг аймгуудын хооронд дайн дажин тасралтгүй явагдаж байсан ч өвөр хоорондоо харилцах харилцаа нь зөвхөн дайн байлдаан төдий байсан мэтээр ойлговол ихээхэн өрөөсгөл талтай болох билээ.

Монгол аймгуудын өвөр хоорондоо болон гадаад бусад улс орон лугаа харилцах харилцаанд дипломат харилцаа чухал үүрэг гүйцэтгэж байв.

Монголд феодалын нэгдсэн төр тогтохоос өмнөх үеийн гадаад харилцааны зарим онцлогийг энд дурдваас: Нэгд, тэдний гадаад харилцааны тогтмол хэлбэрийн нэг нь дайн байсан хэдий боловч элчин харилцаа зохих үүрэг гүйцэтгэж байв. Гэхдээ энэ үед монголын дипломат харилцаа, ер нь нийт гадаад харилцаа нь урьдынхаас нэлээд өргөжиж, Төв ба Дундад Ази, Алс Дорнод, Өмнөд Сибирийг хамарч байжээ. Хоёрт, гадаад улсуудтай харилцах харилцаанд шашны нөлөө ихсэж соёлын харилцаа газар авах шинжтэй болсон байлаа.

Монгол нутагт феодалын нэгдсэн төр тогтохоос өмнөх үеийн олон улсын эрх, түүний зарим нэг зарчмууд, дайн ба найрамдлын асуудал, гэрээ хэлэлцээр байгуулах ёс журмын бүрэлдэн тогтолт, хөгжлийн чиглэл ямар байсан тухай товчоор авч үзэхэд иймэрхүү байсан агаад харин хожим феодалын нэгдсэн улс бүрэлдэн тогтсон үед дээрх асуудлууд хэрхэн гүнзгийрч боловсрон байсныг товч хөндөө.

Дипломат горим. Дорно ба Өрнө дахины олон улс орон лугаа улс төр, эдийн засаг, соёл, шашны өргөн харилцаа барьж агсан монгол улс нь өөрийн өвөрмөц шинжтэй тусгай боловсруулсан дипломат горимтой байжээ. Энэхүү горим нь дипломат харилцлага ба дипломат ёслолын журамлалаас бүрдэж байв. Бас эдгээр асуудлыг эрхлэн явуулах тусгай албан төрийн байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан байлаа. Улсын гадаад харилцааг «төрийн хэрэг эрхлэх газар (яам)»⁶, дипломат ёслол журамлалыг «гэрээ ёслол эрхэлсэн түшмэл»⁷, харь орны элчин төлөөлөгчдийн хэргийг эрхэлсэн өртөө буудлын тусгай «яам»⁸ буюу төрийн зарим байгууллагууд тус тус эрхэлдэг байсан байна.

Хэдийгээр гадаад харилцааны хэргийн дээд эрх гагцхүү хааны гарт төвлөрч байсан боловч төрийн хэрэг эрхлэх газар (яам) нь дипломат харилцааны хэрэгт ихээхэн нөлөө бүхий байв. Тэр нь харь газарт элчинг илгээх, тэдний дэв зэргийн эрхийг баталсан пайзыг шийтгэн олгох, харь орнуудтай эдийн засаг, соёл шашны харилцааг барих, гэрээ хэлэлцээр байгуулах тэдний дотоод дахь улс төр, цэрэг, эдийн засгийн байдлыг заншлах, харь улсаас ирсэн элч төлөөлөгчдийг ёсолж хүндэтгэх, тэднийг эзэн хаанд бараалхуулах зэрэг хэргийг гардан эрхэлж байлаа. Энэхүү яамны дэв зэргийн ялгааг сийрүүлбэл: тэргүүн ноён, гэрээ ёслол эрхлэх түшмэл, бичээч түшмэл, бичээч гэх мэт албан тушаал байсан бололтой юм.

Эдгээр албан тушаалтнууд нь гадаад харилцааны хэрэгт өөрийн гэсэн тодорхой үүрэгтэй байсныг дашрамд дурдах нь зүйтэй. Ингэж

⁶Мэндабэйлу. М., 1974, 73-р тал.

⁷Мөн тэнд.

⁸Ч. Далай. «Юан гүрний үеийн Монгол», УБ., 1976. 84-р тал

«төрийн хэрэг эрхлэх яамыг» албан тушаалын тодорхой дэв зэргийн ялгаатайгаар эмхлэн байгуулсан нь монголчууд гадаад харилцаа ба дипломат үйлийг ихээхэн анхаарч хөгжүүлж байсныг нотолж байна.

Монголчууд элч төлөөлөгчөө харь оронд илгээхдээ баримталдаг ёс журамтай байснаас гадна бусдын элчийг хүлээн авах, ёсолж өнгөрүүлэх нарийн дэг журамтай байжээ. Энэ тухай өмнөд Сүн улсын элчин Жао Хун «Монгол Татарын бүрэн тэмдэглэл» хэмээх бүтээлдээ хааны зарсан элчийг тохиолдсон газар орны эрх баригчид цөмөөр хүндэтгэн өнгөрүүлэх, элчийн дэв зэргийн их багыг харгалзахгүй алба хэрэг, танхимд хүндэт суудалд суулгах, хүндэт харуул гаргаж сахиулах, элчинг их хаалгын гадна угтан уулзахдаа хэнгэрэг дэлдэн хөгжим үүсгэн, хиур далбаа барьж жагсах, монголын хааны ордонд элчинг хүрэлцэн очиж хаанд бараалхахад төдий л их ёс гүйцэтгэхгүй, нам шулуун үг өгүүлэх нь тэдний эртний эгэл ёс, төр, зан заншил нь эвдрээгүйн тэмдэг гэсэн байна.⁹ Үүний хамт монголчууд харийн элч нараас өөрийн ёс журмыг дагахыг шаарддаг ба эс дагаваас их хаанд бараалхуулдаггүй байжээ. Элчийг бараалхуулахдаа төлөөний сайд нар харь улсын хаад ч байсан их хааны хөрөгт мөргөхийг заавал шаарддаг байв. Галыг хамгийн ариун зүйл гэж хүндэтгэх заншил монголчуудын дунд байснаас хоёр галын хоорондуур гаргаж ариутгахыг шаарддаг байсны дээр их хааны хөрөгт мөргүүлэх нь монголын төрийг үнэнхүү хүндэтгэж буйгийн илрэл болохын хамт ертөнцийг захирагч эзэн нь монголын их хаан мөн гэдгийг зөвшөөрүүлэх гэсэн эчнээ агуулгатай байжээ.

Монголчууд дипломат бичгээр харилцахдаа уйгуржин монгол, дөрвөлжин үсэг хэрэглэн бичиж байсны зэрэгцээ хаан, хааны төлөөний сайдад гадаад орны элчин бараалхахад хэлмэрч хэрэглэж байжээ. Бас монголын хаад гадаадын элчинг хүндэтгэн сархдаар дайлан илдний наадам үзүүлдэг байсан байна. Гаднын элч нарын халдашгүй эрхийг аль болох хүндэтгэн хамгаалж, тэднийг зам зуур явахад нь анхаарал тавин тусламж үзүүлэх заншилтай байсан ажээ.

Өгэдэй хааны үед өртөө замыг бий болгосон нь хэдийгээр эзлэгдсэн улсуудыг гүрний төвтэй холбох дотоод арга хэмжээ боловч бас элчин харилцааны зам чигийг тодорхой зааж, элчийг саадгүй түргэн нэвтрүүлэх болгосон¹⁰ чухал арга хэмжээ байв. Монголын элч нар хааны захисан бүхнийг үг гээлгүй цээжилж чандлан нууцалж явдаг байжээ. Энэ нь монголын уламжлалт дуу бариулах ёсноос үүсгэлтэй юм. Энэ тухай Рашид-ад-дин бичихдээ «Монголчууд эрт цагаас элч нар нь голдуу толгой холбон шүлэглэсэн ёгт уран үгийг цээжээр хэлж дамжуулдаг заншилтай байсан»¹¹ гэжээ. Монголын түүхийн тулгар бичгүүдэд «элчийг дуу бариулж хэлүүлсэн нь»¹², «үг гэж хэл»¹³ гэх мэтээр бичсэн нь үүнийг давхар нотолж байна. Энэ талаар эрдэмтэн Ц. Дамдинсүрэн тайлбарлан бичихдээ: «Алтан бичиг нь их төлөв шүлэг бөгөөд цээжлэвч амархан тул дуу гэж нэрлэсэн мэт»¹⁴.

Дээрх тайлбарын зөв болохыг тэр үеийн элчин харилцааны баримтууд (Өлзийт хааны бичиг гэх мэт) батлах бөгөөд тэгэхдээ албан бичгийг голдуу их гүрний үеэс хэрэглэх болсон ажээ. Үүнээс урьдах үеүдэд амаар дамжуулах арга голлож байсан байна.

⁹Мэндабэйлу. М., 1974, 216-р тал

¹⁰Монголын нууц товчоо. УБ. 1957. 279—280-р зүйл

¹¹Рашид-ад-дин, М., 1952. I боть. II ном. 117-р тал

¹²Монголын нууц товчоо, УБ., 1957. 165-р зүйл

¹³Мөн тэнд. 117. 183—190, 196-р зүйл

¹⁴Монголын нууц товчоо. УБ., 1957. 236-р тал.

Албан бичгийг цээжлүүлэх арга нь бичиг үсэг мэддэггүй байсандаа бус харин тухайн үеийн тус орны нийгмийн үргэлжийн дайн самууны цагт нууцыг алдалгүй байх гол арга нь цээжлүүлэх явдал байв. Учир нь элчин эс уравбаас нууц үл алдагдана. Түүгээр ч барахгүй бичиг бариулан явуулсан ч чухам хэлбэл зохих үг «элчийн аманд бий» гэж тулгар бичгүүдэд дурдсан байдаг.

Монгол улсын дипломат горим нь олон улсын хэв заншлын шаардлагад тохирохуйц байснаас гадна бас өөрийн өвөрмөц онцлогтой байсны зэрэгцээ XIII—XIV зууны үеийн монгол улсын гадаад харилцааны хэв заншлууд тухайлбал харь орнуудад бүрэн эрхт элч нарыг илгээх, гаднын элч төлөөлөгчдийг өөрийн ёс журмыг дагуулан хүлээн авах, гэрээ байгуулах журам нь олон улсын харилцааны хэм хэмжээний хүрээнд зохицож чадахуйцаар байжээ.

ПРАВОВЫЕ НОРМЫ МЕЖГОСУДАРСТВЕННЫХ ОТНОШЕНИЙ МОНГОЛЬСКОГО ЕДИНОГО ФЕОДАЛЬНОГО ГОСУДАРСТВА XIII—XIV вв.

(Р е з ю м е)

Образование в XIII веке монгольского единого феодального государства повлекло за собой расширение и усовершенствование его межгосударственных связей. В то время войны были признанной формой международных отношений и, время от времени, приводили к созданию обширных и, в то же время, непрочных военно-административных объединений.

Монгольское феодальное государство имело весьма оживленные международно-правовые сношения с различными государствами мира. История международных отношений, материальные и литературные памятники средневековья—«Сокровенное сказание», «Сборник летописей» Рашид-ад-дина, «Мэн-да бэй-лу» и многие другие убедительно свидетельствуют о существовании в Монголии в XIII—XIV вв. ряда конкретных международно-правовых норм, в частности, посольского и договорного права, а также правил ведения войны. Например, в Монголии были разработаны формы дипломатического общения и церемониала. Традиционным являлось соблюдение принципа неприкосновенности послов и предупреждения противника прежде, чем идти против него войной.

Эти и другие нормы и правила были обычными нормами международного права.

Развитие международного права в Монгольском феодальном государстве имело свои особенности по сравнению с международным правом государств, существовавших на территории Монголии.

Во-первых, возникли новые институты международного права, носившие ярко выраженный феодальный характер.

Во-вторых, совершенствовались прежние институты международного права. Например, в эпоху феодализма каждый феодал являлся сувереном в пределах своих владений, что оказало некоторое влияние на развитие принципа суверенитета и на разработку норм посольского права.